



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/152

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолын 3, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Элэг бүтэн Монгол" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсугай.

Дарга: О.Бат-Эрдэнэ /Аймгийн Засаг дарга/

Гишүүд: Ц.Эрдэнэсүрэн /Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга/

С.Хулан /Аймгийн ЗДТГ-ын эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн/

Н.Саруулцэцэг /Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн ахлах мэргэжилтэн/

Д.Нямтогтох /Эмнэлгийн тусламжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн/

О.Энхцэцэг /Эрүүл мэндийн газрын статистикч их эмч/

Х.Жаргал /Нэгдсэн эмнэлгийн дарга/

Д.Энхцэцэг /Нэгдсэн эмнэлгийн халдвартын их эмч/

О.Наранчимэг /Нэгдсэн эмнэлгийн хавдрын их эмч/


Ц.Энхцэцэг /ЭМНДХ-ийн эрүүл мэндийн даатгалын тасгийн дарга, байцаагч их эмч/

Нарийн бичгийн дарга: Ц.Энхсайхан /Эрүүл мэндийн газрын дарга/

Хоёр. "Элэг бүтэн Монгол" үндэсний хөтөлбөрийг зохион байгуулах ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан батлуулж, удирдлага зохион байгуулалтаар ханган хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга /Ц.Энхсайхан/-д үүрэг болгосугай.

Гурав. Захирамжийн хэрэгжилтийг улирал бүр хянаж, жилийн эцсийн тайланг 2017 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор багтааж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг ажлын хэсэгт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

000000442